



НИЙТ ТЕНДЕРТ  
ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН  
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 27 99, Факс: (976-11) 26 27 98,  
Цахим шуудан: info@nird.gov.mn  
Цахим хуудас: www.regional.gov.mn

2024. 11. 27 № 24/91

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга хүргүүлэх тухай

“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-аас 2024 оны 11 сарын 11-ний өдөр зарласан “Орон нутгийн хөгжлийн төвд байгалийн нөхцөл нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын ТЭЗҮ /Говь-Алтай/ (МУШС/20240103016)-ийн үйлчилгээ үзүүлэх ажилд ирсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1.	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8-р зүйлд зааснаар гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжтой эсэх?	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8-р зүйлд зааснаар гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжтой.
2.	2.Ахлах зөвлөх болон зарим нэг зөвлөхүүд нь гадаад улсын иргэн бөгөөд энэ чиглэлээр олон улсад ажилласан туршлагатай шаардлага хангасан мэргэжилтэн байж болох уу?	Гадаадын зөвлөх авч болох бөгөөд үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагыг нотлох баримт бичгийн ТШЗ-ны 19.2.б-д заасны дагуу гадаад улсад төгссөн бол дипломын хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.
3.	Тээвэр логистикийн асуудал хариуцсан зөвлөх нь ямар мэргэжил, туршлагатай хүн байх вэ?	Тээвэр логистикийн асуудал хариуцсан зөвлөхийн мэргэжил нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалтын “104 тээвэр үйлчилгээ, мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан мэргэжлийн чиглэл, индексийг дүйцүүлэн ойлгох жагсаалтын “104 тээврийн үйлчилгээ” хэсэгт нийцсэн мэргэжил байж болно.
4.	Бүх зөвлөх доктор зэрэгтэй байх тухай заасан боловч ХАА-н асуудал хариуцсан зөвлөх	ХХААХҮЯ-аас 2024 оны 11 сарын 28-ны өдрийн 02/3757 дугаартай “Тодруулгын хариу хүргүүлэх тухай” албан бичгийн 1-т

001524020670

	<p>доктор зэрэггүй байж болохоор заасан байна зөв үү?</p>	<p>зааснаар “2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13,14-д заасан асуудал хариуцсан зөвлөхөд тавигдах шаардлагын .... докторын зэрэгтэй байх гэснийг “... магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байх” гэж өөрчлөсөн тул ХАА-н асуудал хариуцсан зөвлөх нь магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байна.</p>
<p>5.</p>	<p>Эрчим хүчний салбарын асуудал хариуцсан зөвлөх нь цахилгаан эсвэл дулаан эсхүл бусад ямар эрчим хүчний /жишээ нь сэргээгдэх э.х/ мэргэжилтэй байх шаардлагатай вэ?</p>	<p>ХХААХҮЯ-аас 2024 оны 11 сарын 28-ны өдрийн 02/3757 дугаартай “Тодруулгын хариу хүргүүлэх тухай” албан бичгийн 3-т зааснаар “Эрчим хүчний асуудал хариуцсан зөвлөхийн мэргэжил нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалтын “071 инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл, мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан мэргэжлийн чиглэл, индексийг дүйцүүлэн ойлгох жагсаалтын “071 инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл” хэсэгт нийцсэн мэргэжил байж болно.</p>
<p>6.</p>	<p>Доктор зэргээ хамгаалаад хэдэн жил болсон байх тухай шаардлага байгаа эсэх?</p>	<p>Доктор зэргээ хамгаалаад хэдэн жил болсон байх тухай шаардлага байхгүй.</p>
<p>7.</p>	<p>Хөлсөөр ажиллах гэрээн дээр зөвлөхүүдтэй байгуулсан үнэ хөлсийг заавал бичих шаардлагатай юу?</p>	<p>Хөлсөөр ажиллах гэрээн дээр зөвлөхүүдтэй байгуулсан үнэ хөлсийг бичих шаардлагатай.</p>

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭРДЭНЭБАЯР